



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/400

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.4, 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод 2019 оны 07 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулагдах Олон улсын Улаан загалмайн Улаан хавирган сар нийгэмлэгийн 100 жил, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн 80 жилийн ойн арга хэмжээнд оролцох 20 төлөөлөгчийн унааны зардалд зориулж 3000000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3000000 төгрөг /Гурван сая/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн
А/420 дугаар захирамжийн хавсралт



ОЛОН УЛСЫН УЛААН ЗАГАЛМАЙН УЛААН ХАВИРГАН САР
НИЙГЭМЛЭГИЙН 100 ЖИЛ, МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ
НИЙГЭМЛЭГИЙН 80 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН УНААНЫ ЗАРДАЛ

ДД	Оролцох баг	Хүний тоо	Нэг брийн үнэ	Нийт дүн	Тайлбар
1	Төлөөлөгчид	20	150000	3000000	
	Нийт дүн			3000000	

--oOo--